

## **Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн сахилгын дүрэм**

### ***Нэг.Нийтлэг үндэслэл***

- 1.1 Авлигатай тэмцэх газрын албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахад Монгол улсын Авлигын эсрэг хууль, Төрийн албаны тухай хууль болон энэ дүрмийг баримтлана.
- 1.2 Авлигын эсрэг хуулиар тогтоосон чиг үүрэг, бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гадны нөлөөнд үл автаж, гагцхүү хуульд нийцүүлэн гаргасан Авлигатай тэмцэх газрын даргын тушаал, шийдвэрийг удирдлага болгох, биелүүлэх, хуулийг зөв ойлгож, нэг мөр хэрэглэх, албан үүрэгт ажилдаа санаачлагатай, үнэнч шударга байж, мэдлэг, мэргэшлээ байнга дээшлүүлэх, Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг болон байгууллагын дотоод дүрэм, журмыг чанд сахих нь тус газрын албан хаагчийн үүрэг мөн.
- 1.3 Авлигатай тэмцэх газрын албан хаагчид дараах үндэслэлээр сахилгын шийтгэл ногдуулна.
  - 1.3.1 Авлигын эсрэг хууль, бусад холбогдох хууль зөрчсөн.
  - 1.3.2 Авлигатай тэмцэх газрын даргаас хуулийг дагаж мөрдөх талаар гаргасан тушаал, үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй.
  - 1.3.3 Албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн.
  - 1.3.4 Байгууллагын дотоод дүрэм, журмыг зөрчсөн.
  - 1.3.5 Хуульд заасан албаны чиг үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй.
  - 1.3.6 Тухайн албан хаагчийн хариуцлага, ур чадвараас шалтгаалсан ажлын алдаанаас хууль тогтоомж зөрчигдсөн нь тогтоогдсон.
- 1.4 Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл, зөрчлийг заавал шалгаж тогтоосон байна.

### ***Хоёр. Албан хаагчид тавигдах сахилгын шаардлага***

Авлигатай тэмцэх газрын албан хаагч (цаашид “албан хаагч” гэх) нь Төрийн албаны тухай хуулиар тогтоосон төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг, Авлигын эсрэг хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүргээс гадна дараах шаардлагыг сахин биелүүлнэ.

- 2.1 Байгууллагын буюу албан хаагчийн нэр хүндийг хамгаалж, хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулах;

- 2.2 Захирах, захирагдах ёсыг чанд сахих;
- 2.3 Улс төрийн үзэл бодлоос ангид байж, санаа бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрхээ эдлэхдээ албан тушаалдаа хүндэтгэлтэй хандаж, төрийн албан хаагчийн ёс зүйд харш үйлдэл, эс үйлдлийг гаргахгүй байх;
- 2.4 Албан үүргээ биелүүлэхдээ улсын болон албан ажлын эрх ашгийг ямагт эрхэмлэн дээдэлж, амин хувийн эрх ашигтаа хөтлөгдөхгүй, санхүү бизнесийн ашиг сонирхол, хээл хахуульд автахгүй байх;
- 2.5 Албан тушаалын давуутай тал, боломжийг хувийн зорилгоор ашиглах, аливаа этгээдийн өмнө хууль бус үүрэг хүлээх байдалд өөрийгөө оруулж болзошгүй бэлэг, дурсгалын зүйл, шан харамж авахыг хориглох;
- 2.6 Үндсэн ажил, албан үүргээсээ гадуур хуулиар хүлээн зөвшөөрснөөс бусад ажил, албан тушаал хавсран гүйцэтгэхгүй байх;
- 2.7 Удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан, тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй сөрөг тал, үр дагаварыг хэлж анхааруулж байх;
- 2.8 Улсын болон байгууллагын нууцыг хадгалж, албан үүрэгтэй нь холбогдож илэрхий болсон буюу эсвэл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулахгүй байх;
- 2.9 Удирдлагын зөвшөөрөлгүйгээр албан ажлынхаа талаар нийтэд болон бусдад мэдээлэл өгөх, мэдээлэл дамжуулахыг хориглох;
- 2.10 Тус газрын албан хаагч нь иргэд, байгууллагатай холбоотой аливаа асуудлыг шалгахдаа танил тал харах, бусдыг ялгаварлах, хүнд суртал гаргах, чирэгдүүлэх зэргээр хүний эрх, эрх чөлөөг үл хүндэтгэх байдал гаргахгүй байх;
- 2.11 Байгууллагын өмч хөрөнгө, техник хэрэгсэл, албан хэрэгцээний мэдээ материал, мэдээллийн санг албаны бус зориулалтаар ашиглахыг цээрлэх.
- 2.12 Албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын цагаар, албаны байранд, мөн үүрэг гүйцэтгэж томилолтоор яваа үедээ согтууруулах ундааг хэрэглэх буюу ёс суртахуунд үл нийцэх бүдүүлэг зан авир гаргахыг хориглох.
- 2.13 Авлигын эсрэг хуулийн 25-р зүйлд заасны дагуу Авлигатай тэмцэх газрын даргын зөвшөөрөлгүйгээр албаны болон хувийн

ажлаар гадаадад зорчих, түүнчлэн дотоод, гадаадын байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүний зардлаар аялах, жуулчлах, амрахыг хориглох;

- 2.14 Аливаа уулзалт, дайллага, хүлээн авалтанд оролцохдоо албаны нэр хүндийг дээдэлж, хөндлөнгийн ямар нэг нөлөөнд автахгүй байх;

***Гурав. Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлийг шалгах.***

- 3.1 Албан хаагчаас гаргасан сахилгын зөрчлийг Авлигатай тэмцэх газрын Дотоод аюулгүй байдал, хяналт шалгалтын алба шалгаж шийдвэрлэнэ.
- 3.2 Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлийг шалгах хугацаа 14 хоног байна. Зайлшгүй нэмэлт шалгалт хийх шаардлагатай гэж үзвэл Авлигатай тэмцэх газрын дарга хугацааг 14 хоногоор сунгана.
- 3.3 Авлигатай тэмцэх газрын “Ёс зүйн зөвлөл” нь дүрэмтэй байна. Энэ дүрмийг Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар батална.

***Дөрөв. Шалгалт явуулж дууссаны дараа хийгдэх ажиллагаа***

- 4.1 Албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл тогтоогдсон гэж үзвэл шалгалтын материалтай танилцах эрхтэй болохыг тухайн албан хаагчид мэдэгдэнэ.
- 4.2 Тухайн албан хаагч шалгалтын материалтай танилцаад тайлбар гаргах, нэмэлт шалгалт хийлгэх тухай бичгээр хүсэлт гаргах эрхтэй. Шалгаж буй албан тушаалтан хүсэлтийг хянаж үзээд үндэслэлгүй гэж үзсэн бол тэр тухай хүсэлт гаргасан ажилтанд хариу өгөх, эсхүл үндэслэлтэй гэж үзвэл нэмэлт шалгалт явуулна.
- 4.3 Албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл тогтоогдоогүй бол тухайн шалгалт явуулсан эрх бүхий албан тушаалтан Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга нарт танилцуулж, шалгалтын материалыг байгууллагын архивын нэгж болгон хадгална.
- 4.4 Шалгалтыг иргэн, байгууллага, албан тушаалтны өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу явуулсан боловч тухайн алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлгүй байна гэж үзсэн бол энэ тухай өргөдөл, гомдол, мэдээлэл гаргасан этгээдэд албан ёсоор бичгээр хариу өгнө.

***Тав. Сахилгын шийтгэл ногдуулах***

- 5.1 Тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлтэй гэж үзвэл уг асуудлыг Авлигатай тэмцэх газрын даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.
- 5.2 Удирдлагын зөвлөлөөр хэлэлцэх шаардлагагүй зөрчлийг “Ёс зүйн зөвлөл” хэлэлцэн энэ дүрмийн 6.1.1; 6.1.2-т заасан сахилгын шийтгэлийг хүлээлгэх санал гаргаж болно.
- 5.3 Тус газрын даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хуралд сахилгын зөрчил гаргасан албан хаагчийг өөрийн биеэр байлцуулж, сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлийн талаар шалгасан эрх бүхий албан тушаалтан танилцуулна.
- 5.4 Хэрэв сахилгын зөрчил гаргасан албан хаагчид мэдэгдсэн боловч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Удирдлагын зөвлөлийн хуралд ирээгүй, эсвэл хуралд орохгүй гэж татгалзсан бол тухайн албан хаагчийг биеэр нь байлцуулахгүйгээр асуудлыг шийдвэрлэж болно.
- 5.5 Албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахдаа гаргасан зөрчлийн шинж байдал, шалтгаан нөхцөл, зөрчил гаргагчийн хувийн байдал зэргийг харгалзан үзнэ.
- 5.6 Зөрчил гаргасан албан хаагчид сахилгын шийтгэлийг Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар ногдуулна.
- 5.7 Сахилгын шийтгэлийн төрлийг нэг зөрчилд давхардуулан ногдуулж болохгүй.
- 5.8 Зөрчил гаргасан албан хаагчид сахилгын шийтгэлийг ногдуулахдаа Авлигын эсрэг хууль болон Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн сахилгын дүрмийн аль заалтыг баримталж байгаагаа тушаалдаа заавал дурьдсан байна.  
Харин тухайн албан хаагчийн гаргасан зөрчил нь хөдөлмөрийн харилцаатай холбоотой, эсхүл байгууллагын дотоод журмыг зөрчсөн бол Хөдөлмөрийн хуулийн холбогдох заалтыг, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн бол Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн ёс зүйн дүрмийн холбогдох заалтыг давхар баримталж сахилгын шийтгэл ногдуулна.
- 5.9 Сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагч гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл 30 хоногийн дотор Авлигатай тэмцэх газрын дарга болон зохих шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.
- 5.10 Сахилгын шийтгэл ногдуулсан Авлигатай тэмцэх газрын даргын тушаалыг тухайн албан хаагчид танилцуулж, түүний хувийн хэрэгт шалгасан материалын хамт хадгалах бөгөөд шаардлагатай гэж үзвэл сахилгын шийтгэл ногдуулсан тухай хамт олонд мэдээлнэ.

### ***Зургаа. Сахилгын шийтгэлийн төрөл, түүнийг шийдвэрлэх***

- 6.1 Сахилгын зөрчил гаргасан Авлигатай тэмцэх газрын албан хаагчид дор дурдсан сахилгын шийтгэл ногдуулна.
- 6.1.1 Сануулах
  - 6.1.2 Албан тушаалын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах
  - 6.1.3 Онцгой нөхцлийн нэмэгдлийг 3 сар хүртэл хугацаагаар хасах
  - 6.1.4 Албан тушаал бууруулах
  - 6.1.5 Ажлаас халах
- 6.2 Тус газрын албан хаагчийн сахилга болон ёс зүйг санаатайгаар буюу санамсар болгоомжгүйгээр зөрчсөн, хууль тогтоомжийн заалтыг зөрчсөн, эсхүл албан үүргээ хангалтгүй биелүүлсэн нь сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.
- 6.3 Авлигатай тэмцэх газрын даргын дэргэдэх Удирдлагын зөвлөл нь сахилгын дүрмийн 6.1.1- 6.1.5-д заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулах шийдвэр гаргана.
- 6.4 Албан хаагчаас гаргасан сахилгын зөрчлийн шинж байдал, хор уршгаас шалтгаалан дээрх сахилгын шийтгэлийн төрлөөс дараалал харгалзахгүйгээр сонгон хэрэглэж болно.
- 6.5 Сахилга, дэг журмыг бэхжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй, эрхээ бүрэн эдлээгүй бүх шатны дарга, удирдах албан тушаалтанд сахилгын хариуцлага хүлээлгэж болно.
- 6.6 Авлигатай тэмцэх газрын албан хаагч нь сахилгын ба захиргааны зөрчил нэг дор гаргасан нөхцөлд тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан нь захиргааны шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

### ***Долоо. Сахилгын шийтгэл ногдуулах хөөн хэлэлцэх хугацаа***

- 7.1 Сахилгын зөрчлийг илрүүлсэнээс хойш 6 сарын дотор, сахилгын зөрчил гаргаснаас хойш 1 (нэг) жилийн дотор сахилгын шийтгэл ногдуулж болно.
- 7.2 Энэ дүрмийн 7.1-д заасан хугацаанд тухайн албан хаагчийн хувьд дараах хугацааг хамааруулахгүй

- 7.2.1 Өвчтэй байсан (энэ нь эмнэлгийн байгууллагын магадлагаа, дүгнэлтээр нотлогдсон бол)
- 7.2.2 Ээлжийн амралт эдэлж байсан
- 7.2.3 Жирэмсний амралттай байсан
- 7.2.4 Захиргааны чөлөөтэй байсан
- 7.2.5 Гадаад улсад албан томилолтоор ажилласан
- 7.2.6 Ажлаасаа түр чөлөөлөгдөн гадаад, дотоодын сургалтанд хамрагдсан

### ***Найм. Сахилгын шийтгэлгүйд тооцох***

- 8.1 Сахилгын дүрмийн 6.1.1, 6.1.2 –д заасан сахилгын шийтгэлийг ногдуулсанаас хойш 8 сарын хугацаанд, мөн зүйлийн 6.1.3, 6.1.4-д заасан сахилгын шийтгэлийг ногдуулсанаас хойш 1 жилийн хугацаанд тус тус дахин зөрчил гаргаагүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно.
- 8.2 Сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагч нь гаргасан зөрчлөө бүрэн засаж, үүрэгт ажлаа үлгэр жишээчээр гүйцэтгэж байгаагаар харуулсан бөгөөд сахилгын шийтгэл ногдуулсанаас хойш 6 сарын хугацаа өнгөрсөн бол “ Ёс зүйн зөвлөл”-ийн саналыг үндэслэн Авлигатай тэмцэх газрын дарга тухайн албан хаагчид ногдуулсан шийтгэлийг хугацаанаас өмнө сахилгын шийтгэлгүйд тооцож болно.
- 8.3 Хугацаанаас өмнө сахилгын шийтгэлгүйд тооцоход дараах үндэслэлийг харгалзана.
  - 8.3.1 Сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагч хүсэлт гаргасан.
  - 8.3.2 Хугацааны өмнө сахилгын шийтгэлгүйд тооцуулах тухай шууд захирах даргаас санал гаргасан.
  - 8.3.3 Сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагч нь үндсэн үүрэгт ажилдаа онцгой амжилт гаргаж, гавьяа байгуулсан .
- 8.4 Сахилгын шийтгэлийг арилгаж, сахилгын шийтгэлгүйд тооцохдоо Авлигатай тэмцэх газрын даргын тушаал гаргана.
- 8.5 Албан тушаал бууруулах шийтгэлийг сахилгын шийтгэлгүйд тооцсон буюу сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаанаас өмнө асуудлыг шийдвэрлэсэн нь тухайн албан хаагчийг өмнөх албан тушаалд эгүүлэн тавих үндэслэл болохгүй.
- 8.6 Тус газрын албан хаагч сахилгын зөрчил гаргах үедээ бусдад гэм хор учруулсан бол хохирлыг өөрөө хариуцаж арилгана.

\*

\*

\*